



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 772

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 64 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 677.5 (зургаан зуун далан долоон тэрбум таван зуу) тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон Улсын комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан 183.0 (нэг зуун наян гурав) тэрбум төгрөгийн авто зам, гүүрний барилга байгууламжийн хөрөнгийг бүртгэлд тусгах асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

2.3. Авто зам, гүүрний барилга байгууламжийн хөрөнгийг хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд яамны санхүү хөрөнгө оруулалтын газрын болон бүртгэл, мэдээлэл хариуцсан ажилтны төлөөллийг оролцуулах замаар хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

2.4. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 289 дүгээр тогтооолоор Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төслийн нэгжид шилжүүлэх 169.0 (нэг зуун жаран ес) сая төгрөгийн автомашиныг холбогдох байгууллагад хүлээлгэн өгч тогтоолын хэрэгжилтийг хангуулах;

2.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бий болсон 73.7 (далан турван тэрбум долоон зуун сая) тэрбум хөрөнгийн эзэмшигчийг тогтоон бүртгэлд

123007300
36-r huraldaan.docx

тусгах асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

2.6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хөрөнгийн эзэмшигчийн тогтоох, аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх талаар өгсөн 6 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангулан ирүүлэх;

2.7.Зам, тээврийн хөгжлийн яамны баланст бүртгэлтэй, орон нутгийн чанартай 85.4 (наян таван тэрбум дөрвөн зуун сая) тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий авто зам, 108.4 (нэг зуун найман тэрбум дөрвөн зуу) тэрбум төгрөгийн гүүрний барилга байгууламжид тооллого хийх, цаашид орон нутгийн өмчид хүлээлгэн өгөх асуудлыг судлан шийдвэрлэх;

2.8.Яамны хөрөнгө оруулалт, их засварын тайлангийн бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2017-2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон дуусаагүй ажлын судалгааг нарийвчлан гаргаж, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлт боловсруулан Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх;

2.9.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй, 183.0 (нэг зуун наян гурав) тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий, Төмөртэйн ордоос Хандгайт өртөө хүртэлх төмөр замын асуудлаар Засгийн газраас гарсан тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдлыг судлан хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийх;

2.10.Хамтран ажиллах гэрээний дагуу "Ай Ти Компас" ХХК-д ашиглуулж байгаа Зам, тээврийн хөгжлийн яамны гадна талын зогсоол, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, Засгийн газрын 13 дугаар байрны залгаа, 2 давхар оффисын барилгын талбай, автомашины гараашийг бусдад ашиглуулах үйл ажиллагаандaa Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах;

2.11.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг болон агуулахын эмх цэгцийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах;

2.12.Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийнэ" гэж заасныг мөрдөн ажиллах;

2.13.Тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Тувшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТУВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
772 дугаар тогтоолын хавсралт

Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт,
ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

| Д/д | Зөрчлийн утга | Мөнгөн дүн (тэрбум төгрөгөөр) | Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ |
|-----|---|--|--|
| 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлээгүй. | 183.0 | Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмыг мөрдөн ажиллах. |
| 2 | Эрх бүхий этгээдээс гарсан автомашин балансаас баланст шилжүүлэх тухай тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаагүй. | 0.169 | Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төслийн нэгжид автомашиныг хүлээлгэн өгөх. |
| 3 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ирүүлээгүй. | 117.5 | Тогтоолын биелэлтийг гаргаж ирүүлэх. |
| 4 | Орон нутгийн чанартай зам, гүүрний хөрөнгөд тооллого, дахин үнэлгээ хийгдээгүй. | 193.8 | Тооллого дахин үнэлгээ хийж дүнг ирүүлэх. |
| 5 | Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй Төмөртэйн ордоос Хандгайт өртөө хүртэлх төмөр замын асуудлаар Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй. | 183.0 | Хөрөнгийн ашиглалтын байдлыг судлан хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийх, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангуулах. |
| | НИЙТ ДҮН: | 677.5 тэрбум (Зургаан зуун далан долоон тэрбум таван зуу) | |

-----оо-----